



**НИЙГМИЙН ДААТГАЛЫН
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ**

2015 оны 08 сарын 20 өдөр

Дугаар А/55

Улаанбаатар хот

Журам шинэчлэн батлах тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4, Нийгмийн даатгалын хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1, Засгийн газрын 2015 оны “Дүрэм шинэчлэн батлах тухай” 11 тоот тогтоолоор батлагдсан “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2 дахь хэсгийн 2.6, 3 дахь хэсгийн 3.1, 3.2, 3.3 заалтуудыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах журам”-ыг нэгдүгээр хавсралтаар, “Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцох мэргэжилтний хөдөлмөрийн гэрээ”-ний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх, хяналт тавьж ажиллахыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс /П.Мөнхтулга/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ц.УРТНАСАН

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2015 оны 01 дүгээр сарын 20 -ны өдрийн
А/СС тоот тушаалын нэгдүгээр хавсралт

ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨРИЙН МАГАДЛАЛЫН ШИНЖЭЭЧ ЭМЧ, ТӨРӨЛЖСӨН МЭРГЭЖЛИЙН ЭМЧИЙГ СОНГОН ШАЛГАРУУЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

- 1.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах, томилох, хөдөлмөрийн гэрээ байгуулахтай холбогдсон харилцааг зохицуулахад хуульд өөрөөр заагаагүй бол энэхүү журмыг баримтална.
- 1.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанарт хөндлөнгийн үнэлгээ, судалгаа шинжилгээний ажил зохион байгуулах, Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох магадлал хийх, мэргэжлийн дүгнэлт гаргах чиглэлээр нийгмийн даатгалын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагаас эрх олгосон мэргэжилтэнийг эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч гэнэ.
- 1.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг 3 жил тутамд нийтэд нээлттэй сонгон шалгаруулна.
- 1.4. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулахдаа сонгон шалгаруулалтанд оролцогчдод шударга, ил тод, адил тэгш хандан нээлттэй өрсөлдөөний зарчмыг удирдлага болгоно.
- 1.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчтэй эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцох хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.

Хоёр. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах шаардлага

- 2.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн чиглэлээр зөвлөх чиг үүрэг бүхий салбар зөвлөл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоо, нийгэмлэгүүд нэр дэвшүүлнэ.
- 2.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эмчлэх эрхийн лицензтэй;
- Эмчийн ахлах зэргээс дээш мэргэжлийн зэрэгтэй;
- Амгасан үжирэн магистрын дээш боловсролын зэрэгтэй;

- Багаар ажиллах, үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай, эрүүл мэндийн байгууллагын нэгж хэсгийг удирдаж байсан туршлага бүхий;
 - Ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэлгүй;
 - Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангасан;
- 2.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын төрөлжсөн мэргэжлийн эмч нь дараахь шаардлагыг хангасан байна. Үүнд:

- Эмчлэх эрхийн лицензтэй;
- Эмчийн ахлах зэргээс дээш мэргэжлийн зэрэгтэй;
- Анагаах ухааны магистраас дээш боловсролын зэрэгтэй;
- Багаар ажиллах, үнэлгээ, дүгнэлт өгөх чадвартай;
- Ёс зүйн зөрчилгүй, гэмт хэрэгт холбогдож байгаагүй, ял шийтгэлгүй;
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн шаардлага хангасан;

Гурав. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах үйл ажиллагаа

3.1. Сонгон шалгаруулалтыг мэдээлэх

3.1.1. Нийгмийн даатгалын байгууллага нь эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалт явуулахаас 30 хоногийн өмнө өдөр тутмын сонин, Нийгмийн даатгалын ерөнхий газрын албан ёсны цахим хуудсаар олон нийтэд нээлттэй мэдээлнэ.

Мэдээлэлд эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах шаардлага, бүрдүүлэх материал, хүлээн авах хаяг, харилцах утасны дугаар, материал хүлээн авах, бүртгэх болон сонгон шалгаруулалт явуулах байр, хугацаа зэргийг тодорхой дурьдана.

3.1.2. Мэдээлэлд өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд сонгон шалгаруулах комисс тухай бүрт нь мэдээлнэ.

3.2. Сонгон шалгаруулалтанд нэр дэвшүүлэх

3.2.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчээр ажиллахаар нэр дэвшигч дараахь материалыг бүрдүүлж, сонгон шалгаруулалт зарласан Нийгмийн даатгалын байгууллагад ирүүлнэ. Үүнд:

- Нэр дэвшүүлсэн байгууллагын санал, ажил байдлын тодорхойлолт (Эрүүл мэндийн яамны дэргэдэх мэргэжлийн чиглэлээр зөвлөх чиг үүрэг бүхий салбар зөвлөл, эрүүл мэндийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн болон төрийн бус байгууллага, их, дээд сургууль, мэргэжлийн холбоо, нийгэмлэгийн удирдлагын зөвлөлийн хурлын протоколын хамт)
- Нэр дэвшигчийн өөрийн хүсэлт;
- Анкет (төрийн албан хаагчийн 1-р маягтаар);
- Иргэний үнэмлэхийн хуулбар;
- Боловсролын диплом, мэргэжлийн болон үйл ажиллагаатай холбоотой материалын хуулбар;
- 3x4 хэмжээтэй 2 хувь цээж зураг;
- Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах шаардлагыг хангаагүй болон энэ журмын 3.2-т заасан материалыг дутуу бүрдүүлсэн мэргэжилтнийг сонгон шалгаруулалтанд бүртгэхгүй.

3.3. Сонгон шалгаруулах комиссын эрх, үүрэг

3.3.1. Нийгмийн даатгалын байгууллага нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулах байнгын комисс (цаашид “комисс” гэх)-ыг 5-аас доошгүй хүний бүрэлдэхүүнтэй байгуулна. Комиссыг Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв, орон нутгийн комиссын дарга ахална.

3.3.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмчийг сонгон шалгаруулах байнгын комиссын бүрэлдэхүүнийг Нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төрөлжсөн мэргэжлийн эмчийг сонгон шалгаруулах байнгын комиссын бүрэлдэхүүнийг Нийгмийн даатгалын төв байгууллагын дарга тус тус томилно.

3.3.3. Сонгон шалгаруулах комисс дараахь чиг үүргийг хэрэгжүүлнэ. Үүнд:

- Нэр дэвшигчдийн материалыг хүлээн авч, хянан нэгтгэх;
- Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах;
- Сонгон шалгаруулалтын дүнг хурлаараа хэлэлцэж, тэнцсэн мэргэжилтнүүдийн нэрсийн жагсаалт гаргах;
- Сонгон шалгаруулалтын дүнг тухай бүр мэдээлж байх;
- Сонгон шалгаруулалт явуулсан тухай тайланг Нийгмийн даатгалын төв байгууллагад хүргүүлэх.

3.3.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид тавигдах шаардлагыг хангаагүй болон энэ журмын 3.2-т заасан материалыг дутуу бүрдүүлсэн мэргэжилтнийг сонгон шалгаруулалтанд бүртгэхгүй.

3.3.5. Комисс нь сонгон шалгаруулалттай холбогдсон аливаа асуудлыг

3.4. Сонгон шалгаруулалтыг зохион байгуулах

- 3.4.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчээр ажиллах хүсэлт ирүүлсэн нэр дэвшигчийн өргөдөл, анкет бусад холбогдох материалыг түүнд тавигдах шаардлагатай харьцуулах замаар эхний шалгаруулалт явуулах;
- 3.4.2. Эхний шалгаруулалтад тэнцсэн мэргэжилтэнтэй ярилцлага хийх;
- 3.4.3. Сонгон шалгаруулалтын дүн комиссын гишүүдийн 2/3-оос доошгүй ирцтэй хурлын 50-иас доошгүй хувийн саналаар дэмжигдсэн байх;
- 3.4.4. Сонгон шалгаруулалтын дүнг нэгтгэж танилцуулга бэлтгэх;
- 3.4.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмчийн сонгон шалгаруулалтын дүнг нийгмийн хамгааллын болон эрүүл мэндийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад, төрөлжсөн мэргэжлийн эмчийн сонгон шалгаруулалтын дүнг саналын хамт Нийгмийн даатгалын төв байгууллагад тус тус хүргүүлэх.

Дөрөв. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийг томилон ажиллуулах

- 4.1. Сонгон шалгаруулалтанд тэнцсэн эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нартай "Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс"-ын дүрмийн 2 дахь хэсгийн 2.2, 2.4, 2.5 дахь заалтуудыг тус тус үндэслэн томилж, дүрмийн 2 дахь хэсгийн 2.6-д заасны дагуу хөдөлмөрийн гэрээ байгуулж ажиллана.
- 4.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комисс нь хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаа тогтоох үйл ажиллагаанд шинжилгээ, үнэлгээ, магадлал хийх хуваарийг урьдчилан гаргаж эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмчид хүргүүлнэ.
- 4.3. Урьдчилан гаргасан хуваарийн дагуу эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмчийг томилон ажиллуулах үүргийг шинжээчид нэр дэвшүүлсэн байгууллага хүлээнэ.
- 4.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нь Нийгмийн даатгал болон эрүүл мэнд, эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль, дүрэм, журам, зааврыг баримтлан ажиллана.
- 4.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчид хөдөлмөрийн чадвар алдалтын байдалд хийсэн шинжилгээ, үнэлгээ, магадлал, хуралд оролцсон хугацаа, ажлын үр дүнг харгалзан Нийгмийн даатгалын байгууллага урамшуулал олгоно.

Тав. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийн эрхийг сунгах, эрхийг дуусгавар болгох

- 5.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалыг мэргэжлийн өндөр түвшинд гүйцэтгэж, ёс зүйн болон мэргэжлийн алдаа, зөрчил гаргаагүй, хөдөлмөрийн гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлж ажилласан шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нарыг сунган ажиллуулж болно.
- 5.2. Дараахь тохиолдолд шинжээч эмч болон төрөлжсөн мэргэжлийн эмчтэй хийсэн гэрээг хүчингүй болгож, цуцална. Үүнд:
 - 5.2.1. Мэргэжлийн болон ёс зүйн алдаа гаргасан, гэрээний заалтыг ноцтой зөрчсөн;
 - 5.2.2. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нь өөрийн хүсэлтээр ажиллахаас татгалзсан;
- 5.3. Нийгмийн даатгалын санд хохирол учруулахуйц үйлдэл, эс үйлдэхүйг гаргасан тохиолдолд хуулийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

----- оОо -----

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын
2015 оны 01 дүгээр сарын 20 -ны өдрийн
АСС. тоот тушаалын хоёрдугаар хавсралт

“ЭМНЭЛЭГ ХӨДӨЛМӨР МАГАДЛАЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ОРОЛЦОХ МЭРГЭЖИЛТНИЙ ХӨДӨЛМӨРИЙН ГЭРЭЭ”-НИЙ ЗАГВАР

2015 оны ... дүгээр сарын өдөр

Дугаар ...

Улаанбаатар хот

Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцох мэргэжилтний хөдөлмөрийн гэрээг (цаашид “Гэрээ” гэх) “Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрэм”-ийн 2 дахь хэсгийн 2.6 дахь заалтыг үндэслэн нэг талаас Нийгмийн даатгалын байгууллагын дэргэдэх Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комисс (цаашид “Комисс” гэх) нөгөө талаас шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч (цаашид “Мэргэжилтэн” гэх)-тэй дараах нөхцлийг харилцан тохиролцож 201... оны ...сарын ... өдрөөс эхлэн 201...оны ...сарын ... өдрийг хүртэл хугацаагаар байгуулав.

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нарын эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд оролцохтой холбоотой хөдөлмөрийн харилцааг зохицуулахад оршино.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Комисс нь эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр томилогдсон эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нартай хөдөлмөрийн гэрээ байгуулна.

2.2. Гэрээнд хоёр талын эрх бүхий этгээдүүд гарын үсэг зурж баталгаажуулах бөгөөд гэрээ нь талууд гарын үсэг зурсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

2.3 Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмчийн ажлын үр дүнг харгалзан комиссын гишүүнээр ажиллах хугацааг 1 удаа сунгаж болно.

2.4 Гэрээний нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй, мэргэжлийн болон ёс зүйн алдаа, иргэн (даатгуулагч)-ийн хөдөлмөрийн чадвар алдалтыг хуурамчаар тогтоосон нь нотлогдсон тохиолдолд гэрээг цуцлах хүртэл арга хэмжээ авна.

Гурав. Нийгмийн даатгалын байгууллагын эрх, үүрэг

3.1. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль, эрхзүйн акт, холбогдох мэдээллээр тогтмол хангах, ажиллах орчин бүрдүүлэх;

- 3.2. Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтыг бууруулах, сэргийлэх чиглэлээр хийгдэх сургалт, судалгаа шинжилгээний ажлыг дэмжих, зохион байгуулах;
- 3.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын шинжээч эмч, төрөлжсөн мэргэжлийн эмч нарт зүй ёсны шаардлага тавих, ажлын гүйцэтгэлд нь хяналт тавих;
- 3.4. Мэргэжилтэнд хуралдаж ажилласан цагийн хөлсийг ажилласан цагаар тооцож, мөрдөж буй тарифийн дагуу олгох;
- 3.5. Мэргэжилтний ажлын үр дүнг харгалзан урамшуулал олгох талаар санал дэвшүүлж, шийдвэрлүүлэх;
- 3.6. Нийгмийн даатгалын санд хохирол учруулахуйц шийдвэр гаргахад нөлөөлсөн, шийдвэр гарсан (үйлдэл) тохиолдолд нийгмийн даатгалын байгууллага хохирлыг нэхэмжлэн төлүүлэх эрхтэй.
- 3.7. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах комиссын дүрмээр зөвшөөрсөн холбогдох арга хэмжээ авах;

Дөрөв. Мэргэжилтний эрх, үүрэг

- 4.1. Нийгмийн даатгалын болон эрүүл мэнд, эмнэлэг хөдөлмөрийн магадлалтай холбоотой хууль, дүрэм, журам, зааврыг мөрдөн, иргэн (даатгуулагч)-д түргэн шуурхай, чирэгдэлгүй үйлчлэх;
- 4.2. Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтын хувь, хугацаанд магадлал хийх, мэргэжлийн дүгнэлт гаргахдаа мэргэжлийн ёс зүй, шударга ёсыг баримтлах;
- 4.3. Эмнэлэг хөдөлмөрийн магадлах төв комиссын дахин болон бүрдмэл магадлалд оролцох, хамтарсан хяналт шалгалт хийх;
- 4.4. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагааны чанарт хөндлөнгийн үнэлгээ, судалгаа, шинжилгээ хийх;
- 4.5. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд хяналт тавих, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх;
- 4.6. Даатгуулагч (иргэн)-ий хөдөлмөрийн чадвар алдалтаас сэргийлэх, бууруулах чиглэлээр сургалт зохион байгуулах;
- 4.7. Эмнэлэг хөдөлмөрийн магадлалын үйл ажиллагаанд баримталж буй хууль эрхзүйн баримт бичгийг боловсронгуй болгоход санал, зөвлөмж өгөх;
- 4.8. Шинжээч эмч нь орон нутгийн комиссын үйл ажиллагаатай танилцах, мэргэжил арга зүйн зөвлөлгөө өгөх;

- 4.9. Комиссын хуралд бүрэн оролцох;
- 4.10. Хуралдаж ажилласан урамшууллыг цаг тухайд нь олгохыг шаардах;

Тав. Гэрээг дүгнэх

- 5.1. Комисс нь Гэрээг жил бүрийн 01 дүгээр сард багтаан дүгнэж, шинэчлэн байгуулна.
- 5.2. Сонгон шалгаруулалт зохион байгуулсан Нийгмийн даатгалын байгууллага нь гэрээ дүгнэх шалгуур үзүүлэлтийг боловсруулан баталж, дүгнэж ажиллана.
- 5.3. Гэрээг “Бүрэн хангалттай” дүгнэгдсэн тохиолдолд тухайн эмч, мэргжилтэнүүдийг шагнаж урамшуулна.

Зургаа. Бусад

- 6.1. Гэрээг 2 хувь үйлдэж эмч, нийгмийн даатгалын байгууллага тус бүр нэг нэг хувийг хадгална.
- 6.2. Нийгмийн даатгалын байгууллага, мэргэжилтэнтэй аль нэг талаас гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулах болон гэрээг цуцлах саналыг бичгээр гаргавал харилцан тохирч цуцлах буюу зохих өөрчлөлт оруулж болно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

НИЙГМИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫГ
ТӨЛӨӨЛЖ:

.....аймаг (дүүрэг)-ийн

НДХ-ийн дэргэдэх ЭХМК-ийн дарга

...../ /

Гарын үсэг

МЭРГЭЖИЛТЭН:

Овог.....

Нэр.....

...../ /

Гарын үсэг